



ҮЙЛДВЭРЛЭЛ ХУДАЛДААНЫ

“ГАН ХИЙЦ”

ХУВЬЦААТ КОМПАНИ



**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2018 оны ᠘ - сарын 9-ны өдөр

№ 01

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн хурал

зарлан хуралдуулах тухай

Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2018 оны 02-р сарын 09-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Ган хийц ХК-ийн 2017 оны санхүүгийн тайланг дахин шинэчлэн тайлагнаж, Шинэчилсэн тайланг ТУЗ-ийн 2018 оны 03 дугаар сарын 14-ны өдөр дахин танилцуулахыг Санхүүгийн менежер Б.Баярмаад даалгасугай.
2. Аудитын хорооны 2017 оны 10 дугаар сард хийсэн санхүүгийн баримтад хийсэн шалгалтын үүрэг даалгавар, 2018 оны 02 дугаар сарын 09-ны өдрийн ТУЗ-ийн хурлаас өгсөн санал, шүүмжлэл, үүрэг даалгаварт төлөвлөгөө гарган ТУЗ-ийн даргаар батлуулж, 2018 оны 03 дугаар сарын 14-ны өдрийн хурлаар танилцуулж, тайлагнахыг Санхүүгийн менежер Б.Баярмаад үүрэг болгосугай.
3. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2018 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 11:00 цагаас компанийн хурлын байранд хуралдуулахаар зарласугай.
4. Дээрх хурлаар хэлэлцэх асуудлыг дор дурдсанаар бүх гишүүдийн хуралд санал оруулахаар баталсугай. Үүнд:
 - ТУЗ-ийн 2017 оны үйл ажиллагааны тайланг танилцуулах
 - Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нөхөн сонгох
 - Санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэх
 - ТУЗ-ийн 2018 оны зардлын төсөв, Компанийн үйл ажиллагааны 2018 оны зардлын төсвийг батлах

5. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулах ажлын төлөвлөгөөг хавсралтын дагуу баталсугай.
6. 2017 оны үйл ажиллагааны үр дүнгээр ногдол ашгийг нэгж хувьцаанд 100 төгрөгөөр тогтоож, холбогдох Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төвөөр дамжуулан олгохыг ТУЗ-ийн дарга /М.Даваасүрэн/-д даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА

М.ДАВААСҮРЭН

ТУЗ-ИЙН ГИШҮҮД

Д.НЯМЖАВ

Д.ЭНХБААТАР

Э.ДОЛГОРСҮРЭН

Б.ГАНБАТ

Б.ЭРДЭНЭБАЯР

Д.ОЮУНЗУЛ

Ц.ПҮРЭВЖАРГАЛ

ТУЗ-ийн 2018 оны 01 тоот

тогтоолын хавсралт

**“ГАН ХИЙЦ” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит
хурлыг зохион байгуулах ажлын төлөвлөгөө**



№	Гүйцэтгэх ажлын утга	Хугацаа	Хариуцах хүн
1	Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай ТУЗ-ийн шийдвэрийг Санхүүгийн зохицуулах хороо болон хөрөнгийн биржд хүргэх	2018-02-12	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга О.Ууганцэцэг
2	Санхүүгийн тайлан , аудитын дүгнэлтийг хэвлэл мэдээлэлийн хэрэгсэлээр нийтлэх	2018.02.20	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга О.Ууганцэцэг
3	Олон нийтийн хэвлэл мэдээлэлийн хэрэгсэлээр Хувьцаа эзэмшигчдийн хурлын талаар мэдээлэх /Монголын үнэн сонин, UBS телевиз, Хөрөнгийн биржийн цахим хуудас, Ган хийц ХК-ийн цахим хуудас, брокерийн компаниудад мэдээлэх /	2018-02-14 Давтан зар 2018-03-01	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга О.Ууганцэцэг
4	Хурлаар хэлэлцэх асуудлыг бэлэн болгох Үүнд: - ТУЗ-ийн 2017 оны үйл ажиллагааны тайланг танилцуулах - Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нөхөн сонгох - Санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэх - ТУЗ-ийн 2018 оны зардлын төсөв, Компанийн үйл ажиллагааны 2018 оны зардлын төсвийг батлах	2018-03-20	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга О.Ууганцэцэг
5	ХЭ-ийн бүртгэлийг Үнэт цаас төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төвөөс авч бэлтгэх	2018-03-10	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга О.Ууганцэцэг

6	Хурлын байрыг бэлдэх	2018-04-05	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга О.Ууганцэцэг
7	Компанийн үйл ажиллагааны тайланг Санхүүгийн зохицуулах хороо болон Хөрөнгийн биржид хүргүүлэх	2018.04.01 дотор	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга О.Ууганцэцэг
8	Хурлын ирцийг бүртгэн, гишүүдэд хурлын материалыг тараан танилцуулах	2018-04-06	ТУЗ-ийн дарга М.Даваасүрэн
9	Хурлын материалыг бүрдүүлж цэгцлэн зохих байгууллагад хүргүүлж мэдэгдэх	2018-04-09-ны дотор	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга О.Ууганцэцэг